



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2025 оны 10 сарын 10 өдөр

Дугаар А/395

Улаанбаатар хот

Эрүүл мэндийн салбарын 2025-2026 оны
өвөлжилтийн бэлэн байдал, хариу арга
хэмжээний төлөвлөгөөг батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.1 дахь заалт, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.4 дахь хэсэг, Монгол Улсын Шадар сайдын 28 дугаар тушаал, Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 56 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Эрүүл мэндийн салбарт 2025-2026 оны өвөлжилтийн бэлэн байдлыг хангах хариу арга хэмжээний төлөвлөгөө"-г хавсралтаар баталсугай.
2. Төлөвлөгөөний хэрэгжилтийг нэгдсэн удирдлага, мэргэжлийн арга зүй, зохион байгуулалтаар ханган ажиллахыг Эмнэлгийн тусламжийн бодлогын хэрэгжилтийн газар (М.Наранпүрэв)-т даалгасугай.
3. Төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээг хэрэгжүүлж ажиллахыг аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар, бүх шатны эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал нарт үүрэг болгосугай.
4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг Гамшгаас хамгаалах эрүүл мэндийн улсын албанд 2025 оны 11 дүгээр сард багтаан танилцуулахыг Эмнэлгийн тусламжийн бодлогын хэрэгжилтийн газар (М.Наранпүрэв)-т даалгасугай.


САЙД



Ж.ЧИНБҮРЭН

141251036

Эрүүл мэндийн сайдын 2025 оны 10
дугаар сарын 10-ны өдрийн 4/305
дугаар тушаалын хавсралт



ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРТ 2025-2026 ОНЫ ӨВӨЛЖИЛТИЙН
БЭЛЭН БАЙДЛЫГ ХАНГАХ ХАРИУ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хугацаа	Хариуцах байгууллага
Нэг: Удирдлага, зохион байгуулалтын чиглэлээр:			
1.	Салбарын өвөлжилтийн мэдээ, тайланг цахим программд оруулах	2025-2026	ЭМЯ, ЭМХТ
2.	Аймаг, нийслэл, сумын өвөлжилтийн нөхцөл байдал, отор нүүдлээр явж байгаа болон өвөлжилт хүндэрсэн, зудтай бүс нутгийн айл өрх, иргэний (жирэмсэн эх, 0-5 насны хүүхэд, өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй, архаг суурь өвчтэй) бодит тоог 14 хоног тутамд нэгтгэн, сар бүрийн хоёр, дөрөв дэх долоо хоногийн Пүрэв гарагийн 17 цагаас өмнө Эрүүл мэндийн хөгжлийн төвийн admin@hdc.gov.mn цахим хаягаар хүргүүлэх	Тухай бүрт	Аймгийн ЭМГ
3.	Өвөлжилт хүндэрч болзошгүй аймаг, сумдын эрүүл мэндийн байгууллагуудад эрсдэлийн үнэлгээг хийж, судалгаа, тооцоог нэгтгэх ажлыг зохион байгуулах	2025 оны 11 дүгээр сарын 01-ны өдрийн дотор	Аймгийн ЭМГ
4.	Эрүүл мэндийн байгууллагын гамшгаас хамгаалах албаны төлөвлөгөөнд зудын бэлэн байдал, хариу арга хэмжээний төлөвлөгөөг тодотгон аймгийн Эрүүл мэндийн газрын даргаар батлуулж, хэрэгжилтийг ханган ажиллах	Тухай бүрт	Аймаг, нийслэлийн ЭМГ
5.	Төсвийн сахилга батыг чангатгаж, үр ашиггүй зардлыг бууруулан өвөлжилт хүндрэх эрсдэлтэй аймаг, сумдын Эрүүл мэндийн төвийн тусламж үйлчилгээ, яаралтай тусламжид шаардлагатай эм, тарианы нөөцийн бэлэн байдал, түргэн тусламжийн тээврийн хэрэгслийн шатахууны бэлэн байдлыг хангахад зарцуулах, шаардлагатай бол төсөвт зохицуулалт хийн шийдвэрлүүлэх арга хэмжээг нэгдсэн удирдлагаар хангаж зохион байгуулах	2025 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн дотор	Аймаг, нийслэлийн ЭМГ
Хоёр. Урьдчилан сэргийлэх чиглэлээр:			
6.	Эрүүл мэндийн яам, Онцгой байдлын ерөнхий газартай хамтран зудын эрсдэлийн үнэлгээг хийж, хариу арга хэмжээний зохион байгуулалтыг төлөвлөх	2025 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн дотор	ЭМЯ, ОБЕГ
7.	Жирэмсэн эх, 0-5 насны хүүхэд, өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй, архаг суурь өвчтэй зорилтод бүлгийн иргэдэд үзүүлэх эмнэлгийн тусламж,	Тухай бүрт	Аймаг, нийслэлийн ЭМГ

	үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, гэрийн идэвхтэй эргэлт, хяналтыг чанаржуулах, иргэдэд өгөх эрүүл мэндийн зөвлөгөөний үр нөлөөг сайжруулах чиглэлээр ажлуудыг зохион байгуулах		
8.	Нэн тэргүүнд өвөлжилт хүндэрсэн аймгуудын эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг осголт, хөлдөлт, томуу, томуу төст өвчин, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, эмчлэх чиглэлээр давтан сургалтад хамруулан чадавхжуулах, дадлагажуулах	2025-2026	ЭМХТ, ГССҮТ, ХӨСҮТ бүх шатны ЭМБ-ууд
9.	Ард иргэдэд осголт, хөлдөлт, уналт, томуу, томуу төст өвчин, улаанбурхан зэрэг халдварт өвчин, агаарын бохирдолоос урьдчилан сэргийлэх чиглэлээр мэдээлэл, сургалт, сурталчилгааны үйл ажиллагааг хэрэгжүүлэх	2025-2026	НЭМҮТ, Аймаг, нийслэлийн ЭМГ, бүх шатны ЭМБ-ууд
10.	Орон нутгийн Онцгой байдлын газар болон Ус цаг уур, орчны шинжилгээний газраас цаг агаарын урьдчилан сэргийлэх мэдээг тогтмол авч, байгалийн болзошгүй аюулт үзэгдлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг авах, эмнэлгийн тусламжийг үзүүлэх бэлтгэлийг хангах	Тухай бүрт	Аймаг, Нийслэлийн ЭМГ
11.	Хүйтэн сэрүүний улиралд ахуйн галлагаатай холбоотойгоор угаартахаас сэргийлэх, анхны тусламж үзүүлэх зөвлөмжийг хэвлэл мэдээллийн хэрэгсэл, нийгмийн сүлжээгээр тогтмол түгээх	2025-2026	НЭМҮТ, НЭМГ
12.	Зоонозын гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлж, эрт сэрэмжлүүлгийг ард иргэдэд хүргэж, хариу арга хэмжээний бэлэн байдлыг хангах	2025-2026	ЗӨСҮТ, НЭМҮТ ЭМЯ
13.	Товлолын дархлаажуулалтын үйл ажиллагааг тасалдуулахгүй байх зохион байгуулалтыг хийх	2025-2026	ХӨСҮТ, Аймаг, нийслэлийн ЭМГ
Гурав. Эмнэлгийн тусламж, үйлчилгээний чиглэлээр:			
14.	Отор нүүдлээр өвөлжиж, хаваржих малчдад эмнэлгийн тусламж, үйлчилгээг харьяалал харгалзахгүй үзүүлж, явуулын эмнэлгийн багаар үзүүлэх хуваарь гаргаж ажиллах	2025-2026	Бүх шатны ЭМБ-ууд
15.	Болзошгүй гамшгийн төрөл, учрах хохирлын хэмжээнд тохирсон эм, эмнэлгийн хэрэгслийн нөөцийг бүрдүүлэх	Тухай бүрт	ЭЭХХЗГ, Бүх шатны ЭМБ-ууд
16.	Томуу, томуу төст өвчний оргил үед эмнэлгийн орны ачааллыг зохицуулах төлөвлөгөө гарган, бэлэн байдлыг хангах	2025 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн дотор	ЭХЭМҮТ, ХӨСҮТ, Аймаг, нийслэлийн ЭМГ
17.	Улаанбурхан өвчин болон бусад амьсгалын замын халдварын шалтгаанаар хэвтэн эмчлүүлэх орны зохион байгуулалт, бэлэн байдлыг хангах	2025 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн дотор	ХӨСҮТ, Аймаг, нийслэлийн ЭМГ
18.	Зуданд нэрвэгдсэн малчин өрхийн байршлын судалгаа гаргаж, эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх ажлыг шуурхай зохион байгуулах	Тухай бүрт	Аймгийн ЭМГ

19.	Өвөлжилт хүндэрч болзошгүй баг, сум, аймагт амьдарч байгаа болон отор нүүдэл хийх айл өрхийн 0-5 хүртэлх насны хүүхэд, жирэмсэн эх, ахмад настан, байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй иргэний тоог гаргах, эрүүл мэндийн байдлыг хянаж, зөвлөмж өгөх, эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх боломжтой төв суурин газарт татах ажлыг зохион байгуулах	2025-2026	Аймгийн ЭМГ
20.	Яаралтай тусламжийн үед ашиглах зөөврийн тоног төхөөрөмжүүдийн бэлэн байдлыг MNS 6717:2018 стандартын дагуу хангаж, мөн эрүүл мэндийн байгууллагуудын нөөц цахилгааны эх үүсвэрийн бэлэн байдлыг хангах	2025-2026	Аймаг, нийслэлийн ЭМГ
21.	Зайлшгүй шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгсэл, оношлуур, хүчилтөрөгч, тоног төхөөрөмж, хоол хүнс, ундны ус, ариутгал халдваргүйтгэлийн бодисын нөөцийг тооцож бэлтгэх, шаардлагатай тохиолдолд яаралтай татан авалт хийх, эм, эмнэлгийн хэрэгсэл, урвалж оношлуурын чанарыг алдагдуулахгүйгээр тээвэрлэх, хадгалах, тараах нөхцөлийг бүрдүүлж бэлэн байдлыг хангах	2025-2026	Аймаг, нийслэлийн ЭМГ, ЭЭХХЗГ
Дөрөв.Төлөвлөгөөний хэрэгжилтийг тайлагнах чиглэлээр:			
22.	Төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг нэгтгэн сар бүрийн 2 дахь долоо хоногийн Баасан гаригийн 16:00 цагаас өмнө Эрүүл мэндийн яамны Эмнэлгийн тусламжийн бодлогын хэрэгжилтийн газарт албан бичгээр ирүүлэх	Тухай бүрт	ЭМХТ

ooOoo

ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМ